



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 3 дугаар  
сарын 4-ний өдөр


Дугаар 82

Улаанбаатар  
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт  
оруулах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 197.1-д заасныг үндэслэн  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга  
хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн  
204 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хорих байгууллага, түүний нутаг  
дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм”-ийн 8, 14 дэх заалтын “Хорих ангийн  
дэглэм” гэсэн хэсгийн “хаалттай” гэснийг “нээлттэй, хаалттай” гэж тус тус  
өөрчилсүгэй.
- Хорих ангиудын дэглэмийг өөрчилсөнтэй холбогдуулж хаалттай хорих  
ангийг нээлттэй, хаалттай дэглэмд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах арга  
хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Шүүхийн шийдвэр  
гүйцэтгэх ерөнхий газар (Д.Дамдинцэрэн) нарт тус тус даалгасугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Хууль зүй, дотоод хэргийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ц.НЯМДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 7 дугаар сарын 4-  
ний өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 204

#### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 197.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. (Энэ тогтоолын хавсралтын зарим заалтыг Засгийн газрын 2018 оны 304 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон)
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь баривчлах байр болон Баривчлах ял эдлүүлэх 431 дүгээр ангийг татан буулгаж, бутэц, орон тоог өөрчлөн байгуулагдсан хаалттай хорих ангиудад шилжүүлэх арга хэмжээ авахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга Ц.Амгаланбаярт даалгасугай.
3. Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэмийг шинэчлэн баталсантай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих байгууллагуудыг нээлттэй, хаалттай дэглэмд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Ц.Амгаланбаяр нарт тус тус даалгасугай.
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Амгалан дахь насанд хүрээгүйчүүдийн 411 дүгээр хорих ангийг Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага болгон өөрчлөн зохион байгуулж, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11 дүгээр (Хонхор) хороонд байрлах Баривчлах ял эдлүүлэх 431 дүгээр анги (хуучин нэрээр)-ийн байранд шилжүүлэн байршуулсугай.
5. Хорих байгууллагуудыг өөрчлөн зохион байгуулах, байршлыг өөрчлөх, хоригдлыг хорих ангид хүргэх, цагдан хорих төв, байр, хорих анги болон баривчлах байрнаас суллагдсан хүмүүсийг орон нутагт хүргэхтэй холбогдон гарах зардлыг

батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогтод даалгасугай.

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хархорин дахь 423 дугаар анги, Ховд дахь 457 дугаар ангийн байрыг нээлттэй, хаалттай дэглэмүүд бүхий хорих анги болгон өргөтгөхөд шаардагдах зардлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2018 оны төсвийн төсөлд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 98 дугаар тогтоолын 2, 3, 4 дүгээр зүйл, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 155 дугаар тогтоол, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2007 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 188 дугаар тогтоол, “Хорих ангийн нутаг дэвсгэрийн байршил, ял эдлүүлэх харьяалал, үйлдвэрлэлийн чиглэлийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 51 дүгээр тогтоол, “Хорих ангийн дэглэм өөрчлөн зохион байгуулах тухай” Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 71 дүгээр тогтоол, “Зарим хорих ангийг өөрчлөн зохион байгуулах тухай” Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 460 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Хууль зүй, дотоод хэргийн сайд

С.БЯМБАЦОГТ

**ХОРИХ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙРШИЛ,  
ХОРИХ АНГИЙН ДЭГЛЭМ**

№	Хорих байгууллага	Байршил	Хорих ангийн дэглэм
1	401 дүгээр анги-Нэгдсэн эмнэлэг 403 дугаар анги	Улаанбаатар, Хан-Уул дүүрэг	Хаалттай
2	(Засгийн газрын 2018 оны 304 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон)	Төв аймаг, Лүн сүм	Нээлттэй
3	405 дугаар анги	Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг	Хаалттай (Тусгай нэгж)
4	Эмэгтэйчүүдийн 407 дугаар анги	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	Нээлттэй, хаалттай
5	409 дүгээр анги	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	Хаалттай
6	Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	-
7	413 дугаар анги	Сэлэнгэ аймаг, Мандал сум	Нээлттэй, хаалттай
8	415 дугаар анги	Төв аймаг, Баян сум	Хаалттай
9	417 дугаар анги	Төв аймаг, Мөнгөнморьт сум,	Нээлттэй
10	419 дүгээр анги	Хэнтий аймаг, Өндөрхаан сум	Нээлттэй
11	421 дүгээр анги	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	Нээлттэй
12	423 дугаар анги	Өвөрхангай аймаг, Хархорин сум	Нээлттэй, хаалттай
13	425 дугаар анги	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум	Нээлттэй
14	427 дугаар анги	Төв аймгийн Баяндэлгэр сум, нийслэлийн Багануур дүүрэг	Хаалттай
15	429 дүгээр анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг	Хаалттай
16	433 дугаар анги	Сэлэнгэ аймаг, Мандал сум	Хаалттай
17	435 дугаар анги	Дархан-Уул аймаг, Дархан сум	Хаалттай
18	437 дугаар анги	Орхон аймаг, Баян-Өндөр сум	Нээлттэй
19	439 дүгээр анги	Булган аймаг, Орхон сум	Хаалттай
20	441 дүгээр анги	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	Нээлттэй
21	443 дугаар анги (Засгийн газрын 2018 оны 304 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон)	Хөвсгөл аймаг, Мөрөн сум	Нээлттэй
22	445 дугаар анги	Дархан-Уул аймаг, Дархан сум	Нээлттэй
23	457 дугаар анги	Ховд аймаг, Жаргалант сум	Нээлттэй, хаалттай
24	Цагдан хорих 461 дүгээр анги	Улаанбаатар, Баянгол дүүрэг	Хаалттай
25	Архангай аймаг дахь Цагдан хорих байр	Архангай аймаг, Эрдэнэбулган сум	Нээлттэй
26	Баян-Өлгий аймаг дахь Цагдан хорих байр	Баян-Өлгий аймаг, Өлгий сум	Нээлттэй
27	Баянхонгор аймаг дахь Цагдан хорих байр	Баянхонгор аймаг, Баянхонгор сум	Нээлттэй
28	Булган аймаг дахь Цагдан хорих байр	Булган аймаг, Булган сум	Нээлттэй
29	Говь-Алтай аймаг дахь Цагдан хорих байр	Говь-Алтай аймаг, Алтай сум	Нээлттэй
30	Дорнод аймаг дахь Цагдан хорих байр	Дорнод аймаг, Хэрлэн сум	Нээлттэй
31	Дорноговь аймаг дахь Цагдан хорих байр	Дорноговь аймаг, Сайншанд сум	Нээлттэй
32	Дундговь аймаг дахь Цагдан хорих байр	Дундговь аймаг, Сайнцагаан сум	Нээлттэй
33	Завхан аймаг дахь Цагдан хорих байр	Завхан аймаг, Улиастай сум	Нээлттэй
34	Өвөрхангай аймаг дахь Цагдан хорих байр	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум	Нээлттэй
35	Өмнөговь аймаг дахь Цагдан хорих байр	Өмнөговь аймаг, Даланзадгад сум	Нээлттэй
36	Сүхбаатар аймаг дахь Цагдан хорих байр	Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум	Нээлттэй
37	Сэлэнгэ аймаг дахь Цагдан хорих байр	Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум	Нээлттэй
38	Төв аймаг дахь Цагдан хорих байр	Төв аймаг, Зуунmod сум	Нээлттэй
39	Увс аймаг дахь Цагдан хорих байр	Увс аймаг, Улаангом сум	Нээлттэй
40	Хөтөл дэх Цагдан хорих байр	Сэлэнгэ аймаг Сайхан сум	Нээлттэй
41	Тосонцэнгэл дэх Цагдан хорих байр	Завхан аймаг Тосонцэнгэл сум	Нээлттэй
42	Налайх дүүрэг дэх Цагдан хорих байр	Налайх дүүрэг	Нээлттэй



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар  
сарын 10-ны өдөр


Дугаар 304

Улаанбаатар  
хот

Хорих анги болон төрийн өмчит үйлдвэрийн  
газар татан буулгах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 197.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төв аймгийн Лүн сумын Авдрант дахь 403, Хөвсгөл аймгийн Мөрөн суман дахь 443 дугаар хорих анги болон 403 дугаар хорих ангийн дэргэдэх "Авдрант хайрхан" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг тус тус татан буулгасугай.
2. Хөвсгөл аймгийн Бүрэнтогох сумын "Нүүрстэйн ам" нэртэй газарт байрлах 83 га, Төв аймгийн Лүн сумын "Авдрант" нэртэй газарт байрлах 31 га бүхий уурхайн талбай болон тэдгээрийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус буцаан өгөхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Ц.Амгаланбаярт, уурхайн талбайг хүлээн авахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд тус тус даалгасугай.
3. Татан буугдсан хорих антиудын эд хөрөнгө, төсөв, санхүү, орон тоог хууль тогтоомжид заасны дагуу шилжүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид, "Авдрант хайрхан" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Ц.Амгаланбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт тус тус даалгасугай.
4. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2017 оны 204 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм"-ийн 2, 21 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.
6. Энэ тогтоолыг 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Хууль зүй дотоод хэргийн сайд

Ц.НЯМДОРЖ